

## Ч.Тамир

*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш*

## МОНГОЛЫН “ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ”: ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС

**Abstract:** This article is considered internal factors of Mongolian “perestroika” during 1988-1989. Batmunkh and his team had started mongolian version of perestroika from 1988 V central committee plenum. There are several important factors influenced Mongolian perestroika. It is including limited free media, economic crisis, nationalist idea, multycandidate system, ruling party’s internal reform and scholar’s debate. Author concluded Mongolian internal factor is important to influence to established new protest movement and regime change process.

**Key world.** Perestroika, socialist system, glaslit, economic crisis, party internal reform, V party plenum

1985 оноос ЗХУ-д өрнөж байгаа “өөрчлөн байгуулалт” монголд хэрхэн хэрэгжүүлэх талаар лидерүүдийн байр суурь зарчмын зөрүүтэй байлаа. Тухайн үед болзвол байдлаар удирдлагын дээд төвшинд Д.Содномоор тэргүүлүүлсэн засгийн газар талын “технократ бүлэг”, Ц.Намсрай удирдсан намын талын “үзэл суртлын бүлэг” гэсэн хоёр бүлэг өрсөлдөж байлаа. Энэ хоёр лидер аль аль нь Цэдэнбалыг огцорсны дараа УТТ гишүүн болсон бөгөөд бусад удирдагч нарын дунд хоёулаа харьцангуй залуу байв. Ж.Батмөнхийн хувьд хэдийгээр “технократ бүлэг”-ийн угшилтай ч Цэдэнбалын дараа дээд удирдлага болсны дээрх бүлгүүдийн аль нэгийг нь дэмжихгүй төвийг сахих болжээ. Чухам энэ гурван хүн монголын өөрчлөн байгуулалтыг ерөнхий бодлогыг гардан явуулж байв. Тэгэхлээр монголын өөрчлөн байгуулалт яг хэзээнээс эхэлсэн гэж тооцох вэ? Үүнд тодорхой хариулт олохын тулд 1986 оны МАХН-ын XIX хурлаас хойш хуралдсан Намын Төв хорооны бүгд хурлын сэдвүүдийг өөр хооронд нь харьцуулан үзье (МАХН-ын түүхэн замнал 1995 х247).

	НТХ-ны бүгд хурал	Он сар өдөр	Хэлэлцсэн сэдэв
1	II бүгд хурал	1986-12-5	“МАХН-ын XIX их хурлын шийдвэрийн биелэлтийн явц, намын байгууллагын зорилтын тухай” ЕНБД-ын илтгэлийг хэлэлцэв
2	III бүгд хурал	1987-6-30	“Үйлдвэрлэлийн үр ашиг, чанарыг дээшлүүлэх зорилтын тухай” СнЗ-ын даргын илтгэлийг хэлэлцэв.
3	IV бүгд хурал	1987-12-10	“Мал аж ахуйг хөгжүүлэх, хөдөөгийн хөдөлмөрчдийн ахуй, соёлын нөхцөлийг сайжруулах зорилтын тухай” ЕНБД-ын илтгэлийг хэлэлцэв.
4	V бүгд хурал	1988-12-21-22	“Намын зохион байгуулалт үзэл сурталын ажлыг сайжруулах шинэ зорилтын тухай” ЕНБД-ын илтгэлийг хэлэлцэв.
5	VI бүгд хурал	1989-6-22	“Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, их барилгын ажлыг сайжруулах тухай” асуудлыг хэлэлцэв.
6	VII бүгд хурал	1989-12-11	“МАХН-ын эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” ЕНБД-ын илтгэлийг хэлэлцэв.

Хүснэгтээс харахад намын зүгээс албан ёсны болгож зарласан бодлого нь технократуудын санаачлагаар “эдийн засгийн реформ”-ын асуудлыг хөндсөн нь 1987, 1989 онуудад байна. Харин үзэл сурталчдын шахалтаар “улс төрийн реформ”-ын асуудлыг хөндсөн нь гагцхүү 1988 он байна. Гэхдээ 1985 оноос ЗХУ-д хийгдэж эхэлсэн “ил тод байдал”, “өөрчлөн байгуулалт” монголд хэрхэн тусгалаа олсон цаг хугацааны талаар гурван янзын санал бий.

Эхний санал нь өөрчлөн байгуулалт нь 1986 оны МАХН-ын XIX их хурлаар “аль ч газар шинэ байдлаар бодож сэтгэх, туурвин бүтээхэд гол анхаарлаа хандуулбал зохино” гэж хэлснийг иш үндэс болгосныг улмаар ардын аж ахуйн бүх төвшинд эдийн засгийн аргаар удирдах саналыг дэвшүүлсэн, мөн 1987 оноос аж ахуй, эдийн засгийг өөрчлөн байгуулах зорилт дэвшүүлсэн нь зөвлөлтийн өөрчлөн байгуулалтын бодлоготой (Сэджев ба Браун ба Гоммел, 1997 х90) ижил бодлого явуулж эхэлсний нотолгоо гэжээ. Энэхүү саналыг тухайн үед томоохон өндөр албан тушаал хашиж байсан, эрдэмтэн Л.Намжим ихээхэн дэмжсэн юм. Тэрээр “МАХН-ын XIX их хурал урьдынхаас өөр байдалтай болж асуудалд бодитой хандах, түүхэн үнэнийг зөвөөр ойлгох, ил тод байдлыг хэвшүүлэх, ардчиллыг дэлгэрүүлэх өргөн бололцоог нээсэн, ялангуяа эдийн засгийн тогтолцоо, арга механизмыг боловсронгуй болгох алхам хийхэд түлхэц болсон.

Тус их хурлын төлөөлөгчид Монгол улсад бүрэлдэн тогтсон төвлөрсөн удирдлага, захиргаадалтын систем, банк санхүүгийн журам, тэдгээрийн дутагдал, доголдлыг илэн далангүй шүүмжлэн ярилцсан юм. Тэгээд ч намын энэ их хурлын шийдвэр санал шүүмжлэл, уур амьсгалын нөлөөгөөр 1986-1987 оноос эхлэн улсын төвлөрсөн эдийн засгийн тогтсон журам, удирдлага, төлөвлөлт, аж ахуйн механизмыг өөрчлөх, ардчилал, ил тод байдал, олон янзын үзэл бодлыг өрнүүлэх талаар нам, төр засгийн хэд хэдэн чиглэл шийдвэр гарч зарим тодорхой алхмууд хийгдэж, бодитой арга хэмжээ авагдаж байсан юм” гээд ийм нөхцөл байдалд 1988 оны 12-р сарын тавдугаар бүгд хурал болсон билээ гэжээ (Намжим, 2000х720). Хоёр эрдэмтэд хоёулаа 1986 оноос “өөрчлөн байгуулалт” эхэлсэн гэсэн санааг дэмжсэн байна. Харин Д.Болд-Эрдэнэ үүнийг шүүмжилж байгаа юм. Тэрээр өөрийн санааг үндэслэхдээ “XIX их хурал дээр “...намын эдийн засгийн бодлогын ойрын жилүүдийн гол зорилт бол нийгмийн үйлдвэрлэлийг давшингүй хөгжүүлэх, үр ашгийг нь дээшлүүлэх энэ үндсэн дээр ард түмний аж-байдлын цаашдын өсөлтийг хангах явдал мөн” хэмээн хэлсэн нь нэгдүгээрт тухайн үеийн нөхцөл байдлыг “зогсонги” нөхцөл байдалд орсон гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байгааг мөн эдийн засгийг хөгжүүлэхэд л гол анхаарлаа хандуулна гэж дүгнэснээс харж болно (Болд-Эрдэнэ, 2000 х36-37) гэжээ.

Үнэхээр ч Зөвлөлтийн жишээн дээр өөрийн эдийн засгийн болон зогсонги байдлыг Горбачев бүр 1984 оны 4-р сарын НТХ-ны бүгд хурал дээр албан ёсоор хүлээн зөвшөөрч (Горбачев, 1988х21) үүнийг өөрчлөхийн төлөө “өөрчлөн байгуулалт”-ыг эхлүүлсэн бол монголын удирдлага эсрэгээрээ “үйлдвэрлэлийг давшингүй хөгжүүлэх” зэрэг зорилтыг дэвшүүлж байв. Үүнээс харахад энэ үеэс өөрчлөн байгуулалтыг эхэлсэн гэж үзэх боломжгүй юм. Улмаар Горбачев тэргүүтэй шинэ удирдлага өөрийн эдийн засагт тулгараад байсан хямрал, зогсонги байдлыг “Бид иймэрхүү байдлаар цаашаа явах боломжгүй” (Sternthal, 1997х27) хэмээн шинэчлэлийн цогцолбор программыг 1985 онд баталж байхад эсрэгээрээ 1986 оны МАХН-ын XIX их хурал дээр ЕНБД Ж.Батмөнхийн илтгэлд эдийн засгийн байдлыг “өнгөрсөн таван жилийг бүхэлд дүгнэж үзвэл улс орны эдийн засгийн потенциал ихээхэн нэмэгдсэн”, “нийгмийн үйлдвэрлэл өсөхийн хамт ард түмний материаллаг аж байдал, соёлын төвшин дээшлэв”, “УАА үндсэн фонд 1,7 дахин нэмэгдлээ”, “хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний жилийн дундаж үйлдвэрлэл өнгөрсөн таван жилийнхээс 18 хувь өслөө”, “зарим бэрхшээл тохиолдож байсан боловч ард түмний амьдралын төвшинг дээшлүүлэх талаар XVIII их хурлаасаа дэвшүүлсэн гол зорилтыг нам тууштай хэрэгжүүлээ”, “нэг хүнд бодит орлого 12 хувь нэмэгдсэн нь намын талаар XVIII их хурлаас дэвшүүлсэн зорилтыг хангаж байна. Жижиглэн худалдаалах бараа гүйлгээ 24 хувь өслөө” хэмээн бүхэлд нь эдийн засгийн байдлыг сайнаар үнэлсэн байдаг (Монгол ардын хувьсгалт намын XIX их хурал, 1986 х32-33). Мөн тус хурлаас улс төрийн байдлыг “ардын төр бэхжиж, социалист ардчилал гүнзгийрэн хөгжлөө” гээд нийгмийн байдлыг “нийгмийн бүтцэд ихээхэн өөрчлөлт гарлаа. Ажилчин анги тоо, чанарын талаар өсөж нийгмийн дотор тэргүүлэх роль нь

дээшлэв. Ажилчин анги, хоршоолсон ард, хөдөлмөрийн сэхээний холбоо бэхэжлээ” хэмээн бас л өөдрөг дүгнэлтийг хийсэн байдаг байдаг (Монгол ардын хувьсгалт намын XIX их хурал, 1986 х32-33). Тэр ч байтугай 1989 оны 3-р сар гэхэд НТХ-ны хэлстийн эрхлэгч Н.Мишигдорж “хөдөө аж ахуйн салбар зогсонги байдалд орсон... Энэ нь эдийн засаг бүхэлдээ, түүний дотор аж үйлдвэр зогсонги байдалд орсон гэсэн үг биш юм” (Мишигдорж, 1989х31) хэмээн мэдэгдэж байжээ. Үүнээс харахад эдийн засгийн зарим нэгэн арга хэмжээг авч эхэлсэн боловч монголын өөрчлөн байгуулалтыг 1986 оноос эхэлсэн гэх санал нь учир дутагдалтай болох нь харагдаж байна. Магадгүй Г.Очирбат энэ их хурлын шийдвэрийг “хэдийгээр нийгмийн үндсэн өөрчлөлтийн асуудлыг хөндөөгүй ч нийгэмд шүүмжлэлт хандлагыг буй болгоход тус дөхөм үзүүлсэн” (Баркман, 2006 х19) гэж дүгнэснийг бас харгалзууштай.

Хоёрдугаар санал нь МАХН-ын ЕНБД Ж.Батмөнхийн 1987 оны 6 сард МҮЭ-ийн XIII их хурал дээр “Монголын ард түмэн ЗХУКН-аас хэрэгжүүлж эхэлсэн хувьсгалт өөрчлөн байгуулалтыг чин сэтгэлээсээ талархан дэмжиж, түүний туршлагаас өөрийн үйл ажиллагааг шинэ санаа, шинэ эрч хүчээр сэлбэн баяжуулж байна. Лениний намын онол практикийн үйл ажиллагааны энэ туршлага нь манай намаас улс орныхоо өнөөгийн байдалд хэтийн төлөвийг улам тодорхой ойлгож мэдэхэд бодит тус дөхөм болж байна. Өөрчлөн байгуулалт бол манай чиг баримжаа мөн” хэмээн тэмдэглэснийг (Батмөнх, Үнэн 1987) албан ёсоор илтгэлд орсон гэж үздэг. Мөн үүний дараа МАХН-ын ТХ-ны III бүгд хурал дээр (1987) Батмөнх дарга “ЗХУ-д нийгмийн амьдралын бүх хүрээнд хийж байгаа хувьсгалт өөрчлөн байгуулалтын баялаг туршлагыг байнга судлах, түүнээс өөрийн орны социалист бүтээн байгуулалтын ажилд бүтээлчээр тусган хэрэглэх нь манай нам, улс ардын аж ахуйн нийт байгууллагын чухал зорилт гэдгийг дахин цохон тэмдэглэж байна” гэжээ. Чухам үүн дээр үндэслэн П.Очирбат бичихдээ “Намын энэхүү удирдамжийн дагуу манай орны эдийн засгийн салбарт зөвлөлт маягийн зарим өөрчлөлтүүд хийгдэж ил тод байдлыг зарчим нэвтэрч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хандлага боломж буй болж байлаа” хэмээн дүгнэжээ (Очирбат, 1996х136). Мөн “ЗХУ-д нийгмийн амьдралын бүх хүрээнд хийж байгаа хувьсгалт өөрчлөн байгуулалтын баялаг туршлагыг МАХН Оросын монгол судлаач Яскинагийн дүгнэлтээр монголын удирдлага нь зөвлөлтийн өөрчлөн байгуулалтыг шууд хуулбарлахаас болгоомжилж байсан бөгөөд МҮЭ-ийн хурал дээр өөрчлөн байгуулалт гэсэн үгийг оруулж иржээ (Яскина, Трансформация монгольского общества в конце XX века (1984-2000 гг.), 2007 х316) гэсэн юм. Мөн 1987 оны 6 сарын НТХ-ны III бүгд хурал дээр өмнө явуулсан арга хэмжээнүүдийг дурдаад “эдгээр арга хэмжээ нь цар хүрээ далайцаараа өөр боловч агуулга, зорилгоороо ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронд өрнөж байгаа өөрчлөн байгуулалтын үйл явцтай нэгэн адил юм” (Батмөнх, НТХ-ны III бүгд хурал дээр хэлсэн үг, 1987-8 х5) А.Сандерсийн хэлснээр 1988 оныг хүртэл монголд өрнөж байгаа үйл явдлууд нь ЗАУ-тай харьцуулбал агуулгын хувьд ихээхэн бүдэг, хүрээ нь хязгаарлагдмал “ил тод байдал” өрнөж байжээ.

Гуравдугаар санал нь 1988 оны 12 сарын НТХ-ны V бүгд хурал дээр “эдийн засаг, улс төрийн систем, нийгэм, оюун санааны хүрээг бүхэлд нь хамарсан өөрчлөн байгуулалт хийх нь нам, ард түмний хойшлуулшгүй зорилт болж байна” гэснээр намын албан ёсны баримт бичигт туссан гэсэн гэж үздэг (МАХН-ын ТХ-ны V бүгд хурлын тогтоол 1988). М.Миловожевич “1988 онд Москвагаас ирж байсан дарамтын доор “өөрчлөн байгуулалтыг” эхлүүлсэн (Milivojevic', 1991 х3), ялангуяа энэ саналыг тухайн үед нь Намын төв хороонд ажиллаж байсан Н.Багабанди нарын хүмүүс (Пүрэвдорж 2001 х86) мөн сөрөг хүчний АСХ-г үүсгэн байгуулагч Баабар (Улаанхүү, 1990х43) нар дэвшүүлсэн байдаг. Мөн Х.Гүндсамбуу “МАХН-ын Төв хорооны 1988 оны 5-р бүгд хурлаас нийгмийн амьдралын бүх хүрээнд өөрчлөн байгуулалт хийхийг заасан боловч өөрчлөлт алгуурхан, зугуухан хийгдэж байв” (Гүндсамбуу, 2001х390) хэмээн эрчимжилтийг нь хүртэл чамалсан нь бий. Мөн С.Зориг энэ тухай “ардчилсан хөдөлгөөн үүсэх үзэл санаа манай өргөн олон түмний дунд өнгөрсөн олон жилийн үр дагавар болох нийгмийн хямралаас үүдэн гарсан. Ер нь тийм хөдөлгөөн үүсэх нийгмийн уур амьсгал 1988 онд бүрдсэн байсан. Ялангуяа V бүгд хурлын өмнө. Тэгэхдээ тэр үед зохион байгуулах хүч гараагүй. 1988 оны сүүлчээр тийм үзэл бодолтой, ер нь ардчилсан хөдөлгөөн бий болох шаардлагатай гэдгийг ойлгосон хүмүүс олон болсон. Тэр үед ч анхны байгууллага шинээр бий болсон” гэжээ (Янжинлхам, 2012х22). Ж.Батмөнх 1988 оны МХЗЭ-ийн XIX их хурал дээр “ардчилал, эдийн засгийн шинэчлэлийн бодлого явуулахдаа БНМАУ өөрийн өвөрмөц нөхцөл бололцоо, түүхэн онцлог, ах дүү орнуудын өөрчлөн байгуулалтын туршлагын аль алиныг нь харгалзан үзэх үүднээс хандаж байна” гэсэн нь өөрийн орны сонирхлыг харгалзана, яг Москваг шууд дуурайхгүй, гэсэн санаа байсан бөгөөд үүгээрээ нэг талаас харьцангуй бие даасан бодлого

явуулах чиг хандлагын эхлэл, гэхдээ өөрчлөн байгуулалтыг удаашруулах хүлээнзэлийг давхар илэрхийлж байжээ (Батмөнх, Үнэн, 1988). Чухам энэ үеэс л “өөрчлөн байгуулалт”-ийн монгол хувилбарыг гаргаж ирэх чиг шугам тодорч эхэлжээ. Улмаар НТХ, УТТ-ноос дээд зэргээр бэлтгэж төлөвлөсөн 1988 оны V бүгд хурлаас сая л өөрчлөн байгуулалт бодлого болон албан ёсоор хэрэгжиж ирсэн байна.

Ямартай ч Батмөнхийн удирдлагын үед дэглэм зөөлөрч ирснийг бас 1986 оны их хурал өмнөхтэй харьцуулбал харьцангуй нээлттэй, чөлөөтэй хэлэлцүүлэгтэй болсныг оролцогчид тэмдэглэдэг. Үүний дараа бас зарим нэг арга хэмжээ авч байсныг үгүйсгэж болохгүй, гэхдээ лоозон дэвшүүлэх нь намын бүхий л шатны албан тушаалтан хүлээн зөвшөөрсөн албан ёсны бодлого болж томёологдож хэрэгжиж эхлэхэд бэлэн болно гэдэг нь тусдаа зүйлс юм. Дахин хэлэхэд 1987 онд МАХН-ын ЕНБД-ын илтгэлд “өөрчлөн байгуулалт” гэсэн үг орсон боловч намын албан ёсны баримт бичиг тусч тусдаа бодлого болж намын удирдлага бүхэлдээ албан ёсны чиг шугам болж эхэлсэн үе нь 1988 он болж байна. А.Сандерс 1987 оны 12 сард бичихдээ “хэдийгээр ил тод байдал гэсэн ойлголт үнэн сонинд гарч эхэлсэн ч гэсэн зөвлөлтийн хэвлэлтэй харьцуулбал монголын ил тод байдал нь ихээхэн хязгаарлагдмал хүрээнд байна (Sanders, 1987 x40) гэжээ. Тэгэхлээр монголын хувьд өөрчлөн байгуулалт иргэдийн хувьд ихээхэн хүлээлтийг бий болгоод байсан ч бүр 1988 оны сүүлээр эхэлсэн гэж дүгнэж байна. Ялангуяа монголын удирдагч нар эдийн засгийн реформод илүү анхаараад улс төрийн реформийг зөвхөн намын дотоод хүрээний явцуу байдлаар хүлээж авч байв. Үүнийг Сайд нарын зөвлөлийн дарга байсан Д.Содном 1989 оны 12-р сарын бүгд хурал дээр “хувийн өмчийг хүлээн зөвшөөрөх”, “үнийг үе шаттай чөлөөлөх”, “зах зээл төвлөрсөн удирдлага хоёрыг хослуулах”, “гадаадын хөрөнгө оруулах, хамгаалах тусгай хууль гаргах” зэрэг асуудлаар зоримог шийдвэр гаргах шаардлагатай байгаа талаар хэлсэн үгнээс нь харж болно. Түүний хэлснээр Содномын толгойлсон Засгийн газрын эдийн засгийг либералчлах нэг бус удаагийн оролдлогууд нь намын удирдлагуудын зүгээс эсэргүүцэлтэй тулгарч зогсож байжээ (Содном 2003 x111). Гэвч тэрээр эдийн засгийн реформ хийх гол гурван хуулийг 1990 он гэхэд гурвууланг нь батлан гаргасан нь эдийн засгийн реформ арай хурдан байсныг харуулна. Тэгвэл улс төрийн системийн шинэчлэлийн талаар Ц.Намсрай саналууд дэвшүүлж байлаа. Тэрээр УТТ-ны шинэчлэгч томоохон фигур Ц.Намсрай “ЗХУКН-ын мөрийн хөтөлбөрөөс санаа авах зүйл их байна, хуулбарлах хэрэгтэй юмыг хуулбарлах нь хэрэгтэй, дашрамд хэлэхэд олон жил бусдын туршлагыг хуулж, дууриаж ирсэн мөртлөө одоо жинхэн дуурайх цаг болоод байхад хөшүүн хойрго хандлаа гэсэн зэмлэл өнөөдөр сонсогдох болжээ” хэмээжээ (Намсрай, 2007 x262). Мөн тэрээр “НТХ-ны V бүгд хурлаас хөдөлмөрчид их зүйл хүлээж байсан. Манай НТХ дорвитой зоримог шийдвэр гаргаж өөрчлөн байгуулалтыг хийж чадаагүй, хуучин арга барилаараа дөмнөөд өнгөрсөн юм. Манай намын хуучин удирдлага, ер нь ихэнхи удирдагчид дэлхийн хэмжээгээр сэтгэж чадахгүй, тийм ч мэдлэггүйгээс хуучинтайгаа зууралдсаар байсан юм” хэмээн хэлсэн байдаг (Дождорж, 2000x59). Эн бол тэрээр Ж.Батмөнх, Д.Содном нарыг шүүмжилсэн хэрэг юм. Мөн тэрээр МоАХ-г байгуулах анхны байгууллагуудыг үүсэхэд тодорхой нөлөөг үзүүлсэн байдаг. (Чилгэр, 2010x127)

Гэвч Монголын УТТ-ны гишүүдийн дунд “өөрчлөн байгуулалт” улс төрийн утгаараа ч эдийн засгийн утгаараа бусад орнуудтай харьцуулбал хол хоцорч зогсонги, шийдвэргүй, хүлээнзэсэн, эргэлзсэн байдал ноёрхож байв. Даган дуурайж байсан ЗХУ-д нэг намын, гэхдээ олон нэр дэвшигчтэй АДХ-ын сонгуулийг бүр 1989 онд, Унгарт бүр 1985 онд хийчихсэн байхад Монголд лоозон тавьснаас өөр ахиц алга байлаа. Гэвч монголын удирдагч нарын өөрчлөн байгуулалтын мөн чанарыг ойлгоход Ж.Батмөнх хэлсэн нэг үгийг ишлэх хэрэгтэй юм. Тэрээр “Энэ дашрамд тэмдэглэхэд бид тэр үед өөрчлөлт шинэчлэлт хийх тухай ярихдаа социализмаас татгалзах тухай биш харин социализмын өнгөрсөн үеийн алдаа завхралаас ангижирч, социализмыг зүй зохист жинхэнэ зөв голдрилд нь оруулахын төлөө өөрчлөлт шинэчлэлт хийх тухай ярьж байсан гэдгийг цохон тэмдэглэе” (Батмөнх, 2001x22) гэжээ.

Дээрхээс дүгнэн үзэхэд Монголын өөрчлөн байгуулалт нь цаг хугацааны хувьд МАХН-ын 1988 оны сүүлээр болсон V бүгд хурлаас эхэлсэн гэж үзэж болохоор байна. Хэдийгээр энэ хурлын өмнө нэгдүгээрт, эдийн засгийн хэсэгчилсэн шинэчлэл арай өмнөхөн хийгдэж эхэлсэн боловч энэ нь цогцолбор байдлаар хийгдээгүй, хоёрдугаарт

боловсон хүчний шинэчлэлийг эхлүүлсэн боловч үр дүн багатай байсан гэдгийг иш үндэс болгож байгаа юм. Мөн энэ бүгд хурлаас нийгмийн хямралт байдлыг дээд удирдлагын төвшинд албан ёсны баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрч нийгэм улс төрийн бүхий л хүрээг хамарсан өргөн хүрээтэй шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

### Bibliography

- Kaplonski, C. (2004). *Truth, History and Politics in Mongolia*. London and New York Taylor and Francis Group: RoutledgeCurzon.
- Kenney, P. (2002). *A carnival of revolution. Central Europe 1989*. New Jersey: Princeton University Press.
- Ole Bruun and Ole Odgaard. (1996). *Mongolia in transition*. Great Britain: Curzon.
- Rossabi, M. (2005). *Modern Mongolia. From Khans to commissars to capitalists*. Berkeley: University of California Press.
- Sanders, A. (1996). *Historical dictionary of Mongolia*. Lanham Md and London: The Scarecrow Press, Inc.
- Sanders, A. (1990, April 5). Hural for the party-oppositionists claim government is stalling on reform. *Far Eastern Economic Review*, p. 29.
- Sanders, A. (1987, December 10). Looking beyond the steppe. *Far Eastern Economic Review*, pp. 39-44.
- Sanders, A. (1987). *Mongolia*. London: Frances Pinter (Publishers).
- Sanders, A. (1991). Restructuring and openness. In S. Akiner, *Mongolia today* (pp. 57-79). London: T.J press.
- Sanders, A. (1990, February 1). Stirring the hotpot-a new political group presses of democratization. *Far Eastern Economic Review*, pp. 21-22.
- Sternthal, S. (1997). *Gorbachev's Reform. De-Stalinnzation through Demilitarization*. 88 Post Road West, Westport, CT, USA: Praeger Publishers, .
- Батмөнх, Ж. (1986). *Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн Газар.
- Батмөнх, Ж. (1989, Нэгдүгээр сар). Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилт. *Намын амьдрал*.
- Батмөнх, Ж. (1987-8). НТХ-ны III бүгд хурал дээр хэлсэн үг. *Намын амьдрал*, 5.
- Батмөнх, Ж. (2001). *Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй*. Улаанбаатар: Интерпресс.
- Болдбаатар, Ж. (2003). *Түүх зулсан он жилүүдийн ойллого*. Улаанбаатар.
- Болдбаатар, Ч. (2003). МАХН-ын удирдлага: цаг үе хүмүүс (1940-1990). *Түүхийн сэтгүүл*, Соёмбо.
- Болд-Эрдэнэ, Д. (2000). *Монголын улс төрийн нам, намын систем*. Улаанбаатар.
- Бүдээхүү, Т. (2005). *Үнэн 85. 1920-1985*. Улаанбаатар.
- Бямбасүрэн, Д. (1988 оны арван нэгдүгээр сар). БНМАУ-ын нөхөн үйлдвэрлэлийн концепцийн асуудалд. *Намын амьдрал*, 6-13.
- Бямбасүрэн, Д. (1990, Нэгдүгээр сарын 24). Өөрчлөн байгуулалт, социализмын монгол загвар. *Үнэн*.
- Гомбосүрэн, Ц., & Түдэв, Ш. (1988, Аравдугаар сар). Ардчиллыг хөгжүүлэх асуудалд. *Намын амьдрал*, pp. 16-24.
- Горбачев, М. С. (1988). *Өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ: Манай оронд болон дэлхий дахинд*. Улаанбаатар: Улсын Хэвлэлийн газар.
- Гүндсамбуу, Х. (2001). *XX зууны монголын нийгмийн давхраажил хөгжил хандлага*. Улаанбаатар.
- Дамдинжав, Л. (1987, Зургаадугаар сар). Намын боловсон хүчний бодлого. *Намын амьдрал*, pp. 21-29.
- Зардынхан, К., & Дашдаваа, С. (1988, Аравдугаар сар). Шинэчлэлийн үеийн нийгмийн зөрчлийн зарим асуудал. *Намын амьдрал*, pp. 8-16.
- Зардынхан ба Чулуунбаатар. (1991). *Социализм уу эсвэл хөгжлийн гажил уу?* Улаанбаатар: Нууц товчоо хэвлэлийн газар.
- Зардынхан К ба Дашдаваа С ба Цэгмид Я. (1987). Өөрчлөн байгуулалт: БНМАУ-ийн хөгжлийн асуудал. *Намын амьдрал*, 15-30.

- Зардыхан, К. (1990). *Монголын хөдөлмөрчдийн эх оронч интернационалч ухамсар төлөвшихөж байгаа нь*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Зардыхан, К., Чулуунбаатар, Г., & Ядамсүрэн, Ж. (1989, Гуравдугаар сар). БНМАУ дахь социализмын хөгжлийн үзэл баримтлалын асуудалд. *Намын амьдрал*, pp. 6-17.
- Зориг, С. (1989). Социализмын улс төрийн системийг боловсронгуй болгох онолын зарим асуудлаас. *Эрдэм шинжилгээний бичиг, МУИС*, 163-171.
- Иж бүрэн шинжтэй өөрчлөлт хэрэгтэй. (1990, Хоёрдугаар сарын 23). *Үнэн*, p. 4.
- МАХН Онц их хурал*. (1990). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Мишигдорж, Н. (1989, Гуравдугаар сар). Эдийн засгийн хөгжил. *Намын амьдрал*, pp. 29-36.
- Моломжамц, Д. (2010). *Би ганцаараа бүтээсэн юм биш*. Улаанбаатар: Интерпресс.
- Монгол ардын хувьсгалт намын XIX их хурал*. (1986). Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V бүгд хурал*. (1988). Улаанбаатар.
- Нам өөртөө ямар өөрчлөлт хийх вэ? . (1989, Зургаадугаар сар). *Намын амьдрал*, pp. 6-12.
- Намжим, Т. (2000). *Монголын аж ахуй эдийн засаг*. Улаанбаатар 2-р боть: Интерпресс.
- Намсрай. (2007). *Өөрчлөн байгуулалтыг монгол ухаан түшиглэж хийцгээе*. Улаанбаатар: Адмон.
- Намын дотоод мэдээлэл. (1989, Тавдугаар сар). *Намын амьдрал*, p. 55.
- Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг сайжруулах шинэ зорилт. (1988, 11-р сарын 16). *Үнэн*.
- О гласности. (1988, Июль 5). *Известия*.
- Очирбат, П. (1996). *Тэнгэрийн цаг*. Англи: Дэ Баф пресс.
- Пүрэв, Ж. (2004). *Халуун яриа*. Улаанбаатар: Согоо нуур ХХК.
- Ринчин, М. (1996). *Монгол улсын санхүүгийн албаны түүх*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Содном, Д. (2003). *Амьдрал бодол*. Улаанбаатар: Интерпресс.
- Улаанхүү, П. (1990). *Ардчилсан социалист мэдээ материалын эмхтгэл*. Улаанбаатар.
- Үнэний дуу хоолой*. (1999). Улаанбаатар.
- Ядамсүрэн, Ж., & Ядамсүрэн, Ч. (1989 4-р сар). Өөрчлөн байгуулалт-социализмын чадамжийг ашиглах гол зам. *Намын амьдрал*, 11-16